

## **ЗӨВЛӨЛТ, МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ АХ ДҮҮГИЙН ХОЛБООНЫ ТҮҮХЭН ҮЕ ШАТ**

**В. А. АРХИПОВ**

Аугаа их октябрийн социалист хувьсгалын үзэл санааны нөлөөний дор Монголын хөдөлмөрчид үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцэлд боссон юм. Энэ тэмцлийг Монгол ардын хувьсгалт нам манлайллаа. 1921 оны ардын хувьсгалаар хөдөлмөрчин ардын төлөөлөгчид засгийн эрхийг гартаа авлаа.

Энэ хувьсгал империализм, феодализмын эсрэг, ардын ардчилсан шинж чанартай байсан бөгөөд Орос дахь Октябрийн хувьсгалаар эхэлсэн дэлхийн хувьсгалт үйл явцын салшгүй хэсэг нь байв. Хөгжлийн социалист замыг сонгож авсан бүрэн эрхт Монгол улсын үүсэл хөгжлийн бүхий л түүх нь Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон нягт холбоо, олон талт хамтын ажиллагаатай зайлшгүй холбогдоно. Манай хоёр орны хоорондын харилцаа нь цаашдаа дэлхийн социалист хамтын нөхөрлөлд биелэл, хөгжлөө олсон шинэ социалист маягийн улс хоорондын харилцааны дэлхий дахины практик дахь анхны туршлага боллоо. Чухам ийм учир шалтгаанаар ЗСБНХУ, БНМАУ хоёрын хамтын ажиллагааны онцгой түүхэн ач холбогдол тодорхойлогдоно.

Зөвлөлт Монголын ард түмний найрамдал хамтын ажиллагаа эсрэг хүчний дайсагналын хүрээний нөхцөлд олон тооны сорилт шалгалтыг нэр төртэй даван туулж, тулалдааны талбарт Зөвлөлт, Монголын эрэлхэг хөвгүүдийн асгаруулсан цусаар гагнагдсан юм. ЗХУ-тай тогтоосон найрамдал БНМАУ-ын бүрэн эрх, тусгаар тогтнолыг цуцалтгүй бэхжүүлж түүний олон улсын нэр хүндийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

1946 онд Москва хотноо байгуулсан ЗСБНХУ, БНМАУ-ын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ дайны дараах жилүүдийн Зөвлөлт Монголын харилцааны хууль зүйн үндэс болсон юм.

Монголын социалист шатны стратеги зорилтыг шийдвэрлэж улмаар нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт хийх капитализмын шатыг алгасч феодализмаас социализмд шилжих МАХН-ын жанжин шугамын төгс ялалтыг хангахад дээрх гэрээ шинэ түлхэц болсон билээ. Монголын ард түмэн ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламж, бүх талын хамтын ажиллагаанд тулгуурлан, МАХН-ын удирдлагаар улсын секторыг өргөжүүлэх, ардын аж ахуйг хоршооллох, соёлын хувьсгалыг хэрэгжүүлэх, эдийн засагт социалист үйлдвэрлэлийн харьцааны ялалтыг хангах, БНМАУ-ыг хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн орон болгох зорилтыг амжилттай шийдвэрлэсэн юм.

1966 онд ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагаа харилцан туслах тухай гэрээ байгуулагдав. Монгол Улс хөгжлийнхөө шинэ үе -Социализмын материал -техникийн баазыг байгуулж дуусах үедээ оров. Энэ Гэрээ Монгол Улсын дотоод амьдрал болон Олон улсын байдлын чанарын өөрчлөлтийн тусгал боллоо. 1966 оны Гэрээ ЗХУ, Монгол Улсын хоорондын харилцааг гүнзгийрүүлэн, өргөжүүлэх түүхэн үе шатыг нээж өглөө. Манай хоёр орон цаашид ч Зөв-

лөлт-Монголын ард түмний эвдэргүй, уламжлалт найрамдлыг улам бэхжүүлж, социалист интернационализмын зарчмын үндсэн дээр хоёр орны хоорондын ах дүүгийн тусламж, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх шийдвэр төгс байгаагаа батлан харууллаа. Эдийн засаг, шинжлэх ухаан техникийн харилцааг хоёр талын үндсэн дээр түүнчлэн социалист орнуудын бүх талын хамтын ажиллагааны хүрээнд, түүний дотор ЭЗХТЗ-ийн шугамаар улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэх, шинжлэх ухаан, соёлын болон бусад талын харилцааг өргөтгөх талаар ЗХУ, Монгол хоёр харилцан тохиролцсон юм.

Улс хоорондын социалист харилцааны үүсэл, хөгжлийн эх суурийг тавигч ЗХУ, Монгол хоёр хамтын ажиллагааны олон шинэ хэлбэр анх удаа амьдрал практикт хэрэгжүүлж эхэлсэн нь цаашдаа нийт социалист улсуудын харилцаанд өргөн нэвтэрсэн билээ.

Хамтын ажиллагааны ийм хэлбэрт хамтарсан үйлдвэрүүд байгуулахаас гадна, улс ардын аж ахуйн төлөвлөгөөний зохицуулалт хийх, яам, газруудын хоорондох шууд харилцаа, Зөвлөлтийн автономит улс, муж хотууд болон Монголын аймаг хотуудын нөхөрсөг шууд холбоо зэрэг ах дүү хоёр орны харилцан ашигтай үр нөлөө бүхий хэлбэрүүд багтана.

БНМАУ-ын улс ардын аж ахуйн хөгжилд, МАХН-ын XVII мөн XIX их хурлаас дэвшүүлсэн эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх үйлст, юуны өмнө ЗХУ, ах дүү социалист орнуудын бүх талын эдийн засгийн хамтын ажиллагаа болон сэтгэл харамгүй интернационалч тусламж чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улс 1962 онд ЭЗХТЗ-д орсон нь Монгол ба социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хоорондын харилцаанд шинэ хуудас нээлээ. Түүний үрээр хөдөлмөрийн олон улсын социалист хуваарилалтын хүрээ эдийн засгийн олон талт хамтын ажиллагаагаа өргөтгөх хэтийн төлөв Монголд нээгдсэн юм. 1971 онд ЭЗХТЗ-ийн XXV чуулганаар «ЭЗХТЗ-ийн гишүүн социалист эдийн засгийн интеграцийн орнууд хөгжил, хамтын ажиллагааг боловсронгуй болгож, цаашид гүнзгийрүүлэх цогцолбор программыг баталсан нь социалист хамтын нөхөрлөлийн хөгжилд шинэ үе шат боллоо. Энэ программ ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарт хамтын ажиллагааны туршлага хуримтлуулах олон талт интеграцийн таван жилийн төлөвлөгөөнүүд зохиох, урт хугацааны зорилтот программ боловсруулах болон интеграцийг хэрэгжүүлэх арга барилыг боловсронгуй болгоход зайлшгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Жишээлбэл, 1981-1985 орнуудад ЗХУ болон бусад социалист орнуудын эдийн засаг техникийн туслалцаатайгаар БНМАУ-д хөдөө аж ахуй, ойн аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэр, барилга, тээвэр холбоо, уул уурхайн үйлдвэрийн хүрээнд улс ардын аж ахуйн олон чухал объектыг өргөтгөн байгуулсан юм.

ЗХУ-ын тусламжаар БНМАУ-д VII таван жилд барьж эхэлсэн барилга байгууламжаас, хөдөө аж ахуй, аж үйлдвэр болон соёл ахуйн объектын 340 том барилга ашиглалтанд оруулсан байна. Өнгөрсөн таван жилд «Эрдэнэт»-ийн уулын баяжуулах комбинат, Улаанбаатар хотын IV цахилгаан станцын I ээлж, Бага нуурын ил уурхайн зэрэг хамтын барилга байгууламжийн томоохон объектууд ашиглалтанд орлоо. Эрдэнэт хотод хивсний болон хүнсний үйлдвэр, Улаанбаатар хотод керамик эдлэлийн завод, байшин үйлдвэрлэх комбинат, сүлжмэлийн болон ээрмэлийн үйлдвэр, усжуулах системүүдийн барилгууд баригдлаа. Өнгөрсөн таван жилд олон мянган хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууцны барилгын болон соёл-ахуйн объектууд байгуулагдав.

ЗХУ-ын бүгд найрамдах улс, мужууд болон БНМАУ-ын аймаг, хотууд, яам, газар, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, соёлын байгууллагуудын хооронд тогтоосон шууд харилцаа их үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь тэргүүн туршлага нэвтрүүлэх явдлыг эрс түргэтгэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, материаллаг нөөцийг хэмнэх, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох боломж олгож байна.

Зөвлөлт— Монголын харилцаа ямагт харилцан үр ашигтай, эрх тэгш байх зарчмын үндсэн дээр байгуулагдсан гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үүнийг Зөвлөлт Монголын хоорондын худалдаа тасралтгүй өргөжиж байгаа явдал нотолж байна. ЗХУ машин, тоног төхөөрөмж, ард түмний хэрэгцээт төрөл бүрийн бараа Монголд нийлүүлж түүний аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжилд олон талын дэмжлэг үзүүлж байна. Хилийн худалдааны хэмжээ нэмэгдэж түүний бүтэц боловсронгуй болж байна.

1986 оны 5-р сард хуралдсан МАХН-ын XIX их хурал Монголын түүхэнд чухал үе болов. Их хурал дээр МАХН-ын XVIII их хурлаас хойшхи хугацааны нам, ард түмний хөдөлмөрийн үйл ажиллагааг дүгнэж, ойрын жилүүдэд БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх шинэ зорилтуудыг дэвшүүлэв. Их хурал тус орны хөдөлмөрчдийн улс төрийн болон бүтээн байгуулах идэвхи өрнөсөн уур амьсгалд болж өнгөрөв.

Монголын ард түмэн МАХН-ынхаа XIX их хурлаа угтсан өдрүүдэд болон хурлаас хойших үед ч ололт амжилт бүхнээ агуу их В. И. Ленин, Монголын ардын хувьсгалын их удирдагч Д. Сүхбаатар нарын үндэс суурийг нь тавьсан ЗХУКН, Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон найрамдал, ах дүүгийн барилдааны үр шим гэж чин сэтгэлээсээ үнэлэн үздэг юм. Монголын хөдөлмөрчдийн цорын ганц зөв зам бол «Зөвлөлт Оросын ажилчин тариачинтай холбоотойгоор төрийн ба аж ахуйн тусгаар тогтнолынхоо төлөө явуулах тэмцэл» гэсэн В. И. Лениний зөвлөлгөө, «Манай Монгол Улсын тогтнож мандахад дотоодын хүч нь ард түмэн» бөгөөд гадаад байдал дээр түшиг тулгуур нь Зөвлөлийн засагт холбоот улс мөн. Түүнээс өөр зам байхгүй» гэсэн Сүхбаатарын заалтууд хувьсгалын дараах түүхээр болон Монголын ард түмний нийгмийн хурдан бөгөөд бүх талын дэвшил, ололт амжилтаар нотлогдсон юм.

Үүний зэрэгцээ Монгол Улс БНМАУ-ын социализмын бүтээн байгуулалтад асар их тусламж үзүүлж байгаа ЭЗХТЗ-ийн гишүүн, ах дүү, социалист орнуудтай эдийн засгийн харилцаагаа амжилттай хөгжүүлж байна. Унгар улсын тусламжтайгаар VII таван жилд Сонгино дахь Био комбинатын шинэчлэн байгуулалт, Хархорины гурилын комбинат, Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрийг шинэчилэн өргөтгөсөн байна. Болгарын техникийн тусалцаатайгаар 1984 онд Дархан хотод нэхий, нэхий эдлэлийн үйлдвэрийг өргөтгөж, шинэчлэн байгуулах ажил дууссан ба Алтай хотод тоосгын завод баригдаж байна. БНАГУ-аас Улаанбаатар хотод махан бүтээгдэхүүний үйлдвэрийн боловсруулалтын хүчин чадлыг бүрэн ашиглах мах консеревын комбинатыг шинэчлэн засварлах болон тэжээлийн үйлдвэрийг өргөтгөхөд техник — эдийн засгийн тусалцаа үзүүлж байна. БНПАУ Архустайн тэжээлийн аж ахуйн дэргэд багсармал тэжээл үйлдвэрлэх цехийн барилга байгууламжид, Улаанбаатарт жилд 1600 тн. эдлэл үйлдвэрлэх хүчин чадал бүхий нэхмэл бус материалын үйлдвэрийн барилга, Чойбалсан хотод царууц-тоосгын үйлдвэрийн болон Улаанбаатар хотын мод боловсруулах комбинатын барилга байгууламжид техник-эдийн засгийн тусламж үзүүлж байна. Чехосло-

вакийн тусламжтайгаар Улаанбаатар хотын гутлын шинэ үйлдвэр болон арьс ширний үйлдвэрийг шинэчлэн байгуулж байна. Румыний техникийн тусламжтайгаар Улаанбаатарт мебель-картонны үйлдвэрийн барилга ашиглалтанд оруулсан байна. ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эдийн засаг, техникийн асар их тусламж дэмжлэгийн үрээр БНМАУ-ын улс ардын аж ахуйн бүтцэд чанарын өөрчлөлт гарлаа. Тус орны эдийн засаг улам бүр аж үйлдвэржилтийн шинжтэй болж, үйлдвэр, барилга, тээвэр холбоо түргэн хурдацтай хөгжиж байна.

Социализмын орнуудын ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаанд империалистууд болон тэдний хамсаатнууд болох төрөл бүрийн үндсэрхэг үзэлтэн, ревизионистууд бүхий л аргаар саад учруулахыг эрмэлзэж байна. Тэд манай орнуудын хоорондын харилцааг гүтгэх, бидний хамтын ажиллагааг сулруулах буюу таслахыг оролдож байна. Империалист суртал ухуулга, бүх төрлийн оевизионистууд пролетарийн социалист интернационализмыг дэлхийн социалист системийн орнуудын тэгш эрх, тусгаар тогтнолд сөргүүлэн тавихыг оролдож байна. Иймээс социализмын орнуудын энх тайван, аюулгүй байдлын төлөө тэмцлийн хамтын ажиллагааны ач холбогдол улам бүр өсч байна. Социалист орон бүрийн эдийн засаг, улс төрийн тусгаар тогтнолын бодит баталгаа нь гагцхүү социалист хамтын нөхөрлөлийн ялагдашгүй хүчин чадалд оршино.

Орчин үед социалист орнуудын ойртон нягтралт дээд хэмжээнд хүрч, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны төрөл бүрийн салбарт хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл амжилттай ажиллаж орон бүрийн байгаль-газар зүйн нөхцөл, эдийн засгийн бололцоо, түүхэн уламжлалыг сайтар ашиглах боломж олгосон социалист орон тус бүрийн улс ардын аж ахуйн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж өглөө. Улс ардын аж ахуйн төлөвлөгөөнд зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн дагалт, хоршоололтыг гүнзгийрүүлж байна. Түүний зэрэгцээ социалист хамтын нөхөрлөлд багтсан орон бүрийн жинхэнэ тэгш эрх, биеэ даасан байдлыг хангаж байна. Социалист орнууд бүрэн дүүрэн тэгш эрх, харилцан ашигтай, нөхөрсөгөөр харилцан туслалцах зарчмуудыг удирдлага болгон эдийн засаг, улс төр, соёлын салбар дахь хамтын ажиллагаагаа бүхий л талаар боловсронгуй болгож байгаа нь социалист орон тус бүрийн хийгээд нийт социалист хамтын нөхөрлөлийн эрх ашигт нийцэж байна.

Шинжлэх ухаан техникийн дэвшлийн хурдац нь социалист орнуудын хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэхийг шаардаж байна. Учир нь шинжлэх ухаан техникийн хөгжил шинэ маягийн нарийн төвөгтэй машин механизм, тоног төхөөрөмж өдрөөс өдөрт шаардагдаж байгаа өнөө үед, улс бүр тус тусдаа улс ардын аж ахуйн бүх салбарыг түүнд зайлшгүй шаардлагатай зохион бүтээгч боловсон хүчин, хэрэглэгдэхүүн, материалаар хангахад төвөгтэй юм.

Эцсийн дүнд социалист гүрнүүдийн хооронд, үйлдвэрлэлийн хөгжлийн тухайн түвшинд аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нийгмийн ба амьд хөдөлмөрийг хамгийн багаар зарцуулах тийм л харилцаа, үйлдвэрлэх хүчний тийм л хуваарилалтыг тогтоох ёстой. Яагаад гэвэл капитализмыг гүйцэд түрүүлэхэд хамгийн чухал нь социалист үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх явдал юм.

Социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай тогтоосон Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа нь улс ардын аж ахуйн болон соёлын бүх салбарт хамгийн тааламжтай нөхцөл бүрдүүлж тэдгээрийн олон талын хөгжилд тус дөхөм үзүүлж дээд зэргийн үр дүнтэй байдгаараа онцлог юм. Үлэмж хэмжээгээр нээж илрүүлсэн байгалийн нөөц баялагийг техник-

эдийн засгийн талаас нь авч үзэхэд тэр болгон ашиг орлоготой байж чаддаггүй билээ. БНМАУ-ын аж үйлдвэр сүүлийн жилүүдэд хэдийгээр түргэн хурдацтай хөгжиж байгаа боловч тус орны эдийн засгийн тодорхой салбар нь хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй хэвээр үргэлжилж байна. Үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний бараг тэн хагас нь хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдээс гарч байна. Экспортын бараг 70 %-ийг амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн эзлэж байна. Монгол улс социализмын материал-техникийн баазыг байгуулах явдлыг ЗХУ болон социалист бусад орнуудын бүх талын тусламжтай гаар хэрэгжүүлж байгаагийн чухам учир ийм байна.

Монголын Улс ардын аж ахуйн хамгийн зохимжтой цогцолбор бий болгох, эдийн засгийн нааштай өөрчлөлт хийхэд тодорхойлох агшин бол улс ардын аж ахуйг машин, тоног төхөөрөмж, түүхий эд материалаар, хүн амын өргөн хэрэгцээний төрөл бүрийн бараа товараар хангахад онцгой байр эзэлдэг гадаад худалдаа юм. Дэлхийн зах зээл дээр гүйлгээ сайн, эрэлт хэрэгцээ өндөр тийм бараа товараын үйлдвэрлэлээр дагнан мэргэжих замаар хөгжих Монголын гадаад худалдаа нийгмийн хөдөлмөрийг хэмнэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэдгээрийн тоонд мал аж ахуй, хөнгөн хүнсний болон уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүн багтана. БНМАУ-ын үндэсний орлогын 300 гаруй нь гадаад худалдаанаас орж байна. Монгол улс үйлдвэрийн хэрэгслэлийн хэрэгцээнийхээ бараг 90 %-ийг импортын товараар хангаж байгаа ба түүний жижиглэн амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн эзлэж худалдаалах бараа эргэлтийн 60 гаруй хувь нь импортод ноогдож байна. Монгол улс 1 хүнд ноогдох гадаад худалдааны эргэлтийн хэмжээгээр ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын дотор тавдугаар байр эзэлж байна. БНМАУ-ын гадаадад гаргах, дотоодод оруулах барааны 19 өдрийн үнийн нийт дүн 1940 оны бүх бараа эргэлтийнхтэй тэнцэж байна.

Мал аж ахуйг хөгжүүлж түүний товарлаг чанарыг нэмэгдүүлэх хүнс, хөнгөн үйлдвэр, мод боловсруулах болон уул уурхайн зэрэг экспортын чиглэлийн үйлдвэрүүдийг байгуулж бэхжүүлэх явдал Монголын гадаад худалдааг байнга нэмэгдүүлэх бааз нь болдог юм. Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн түүний боловсруулалтад зарим талаар дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн давуугаар бодож урамшуулгын үнэ тогтоох зэргээр Монголын гадаад худалдааны эх булгийг нэмэгдүүлэхэд ах дүү социалист орнууд, ялангуяа ЗХУ-ын үзүүлж буй тусламж асар их ач холбогдолтой юм.

Ард түмний хэрэгцээт аж үйлдвэрийн бараа, уулын олзворлох үйлдвэрийн бүтээгдэхүүн сүүлийн жилүүдэд БНМАУ-ын экспортод улам бүр мэдэгдэхүйц байр эзэлж байна. Экспортын бүтээгдэхүүний ихэнх хэсгийг шинэхэн тоног төхөөрөмжөөр тоноглогсон, шинэчлэн боловсруулсан технологтой үйлдвэрийн газруудад үйлдвэрлэж байна. Хөдөлмөрийн Олон улсын социалист хуваарилалтад БНМАУ-ын үүрэг роль хэлбэрэлтгүй нэмэгдэхэд чухал хүчин зүйл болж байгаа экспортын барааны нэр төрөл сүүлийн жилүүдэд үлэмж ихээр өсөн нэмэгдэж байна.

Өнгөрсөн таван жилд ЗХУ болон БНМАУ-ын хоорондын гадаад худалдааны эргэлт 44 %-иар өсчээ. Зөвлөлтөөс БНМАУ-д 67 мянган нэр төрлийн бараа экспортолж байгаа нь тус орны улс ардын аж ахуйн хөгжил, Монголын ард түмний амьдралын төвшинг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Урт хугацааны худалдааны гэрээний Зөвлөлтийн болон Монголын талын үүрэг амлалт аль аль нь амжилттай биелэгдэж буйг тэмдэглэх нь зүйтэй.

БНМАУ-д Зөвлөлтөөс нийлүүлдэг барааны хэмжээг хэдэн жишээгээр тодорхойлъё. 1981—1985 онуудад БНМАУ-д 3200 трактор, 6400 ачааны

автомашин, 850 автобус, 1,5 сая тонн бензин, 1,3 сая тонн дизелийн шатахуун, 25 мянган тонн шар цай, 176 мянган тонн гурил, 94 мянган тонн будаа, 180 мянга орчим тонн сахар, 260 сая гаруй метр хөвөн даавуу болон бусад олон төрлийн бараа нийлүүлжээ.

Монголын талаас ЗХУ-д зэс молибдены баяжуулсан хүдэр, хайлуур жонш, ноос, мах, хивс нийлүүлсэн байна. Манай зах зээл дээр тэмээний ноос, ямааны ноолуураар хийсэн сүлжмэл эдлэл, мужааны хэрэгсэл, керамзит хайрга эрдэс хөвөн хавтан болон бусад олон нэр төрлийн шинэ бараа гарч ирлээ.

Өнгөрсөн таван жилийн эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны үр дүн Зөвлөлт — Монголын хамтын нөхөрлөлийн олон жилийн түүхэнд шинэ үлэмж ач холбогдолтой алхам болсон явдал түүний дээшлэх шугамаар хэлбэрэлтгүй хөгжлийн яруу тод нотолгоо боллоо.

Урт хугацааны программ хамтын ажиллагааны үндсэн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж өглөө. Түүнд Зөвлөлтөөс Монголд үзүүлж буй тусламжийн стратег зорилт нь хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний болон уул уурхайн үйлдвэрүүдийг хөгжүүлэх явдал хэвээр байх болно гэжээ. Программд мал аж ахуйн тэжээлийн баазын хөгжүүлэхэд чиглэгдсэн хамтын арга хэмжээнүүд, малын тоо толгойг өсгөж, түүний ашиг шимийг болон хөдөө аж ахуйн эдэлбэрийн ашиглалтын эрчимжилтийг нэмэгдүүлэх, хөдөөгийн хөдөлмөрчдийн амьдралын нийгэм-ахуйн нөхцөлийг сайжруулахаар заажээ. Олон улсын хөдөлмөрийн социалист хуваарийн шугамаар БНМАУ-ын үндэсний нөөцийг дээд хэмжээгээр ашиглах арга хэмжээнүүд 2000 он хүртлэх хамтын ажиллагааны явцад хэрэгжинэ.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх урт хугацааны программын тухай хэлэхдээ БНМАУ-ын хөгжлийн хурдац, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд тус дөхөм болж, тус улсын социалист эдийн засгийн интеграцид цаашид өргөнөөр оролцуулах болно гэж тэмдэглэсэн юм.

1985 оны 12-р сарын 25-нд Москвад ЗСБНХУ, БНМАУ-ын 1986— 1990 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөөний зохицуулалтын үр дүнгийн тухай протоколд гарын үсэг зурав. Энэ баримт бичгээр хоёр орны хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойллоо. Тухайлбал, эдийн засгийн салбарт зөвлөлт Монголын байгууллагуудын хүч чармайлт нь нэгэнт эхлээд баригдаж байгаа объектуудыг дуусгах, одоо ажиллаж байгаа үйлдвэр аж ахуйн газруудын өргөжилт, шинэчлэлтэнд түүнчилэн БНМАУ-ын өмнө тавигдаж буй эдийн засаг, нийгмийн нэн тэргүүний зорилтыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой шинэ үйлдвэрийн газруудын барилга байгууламжид чиглэгдэх болно.

Хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрийн материал-техникийн баазыг бэхжүүлэх замаар энэ салбаруудыг цаашид хөгжүүлэх, тэжээлийн баазын хөгжилт, малын тоо толгой ашиг шимийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалтыг эрчимжүүлэх, хөдөө орон нутагт боловсон хүчнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, хөдөө орон нутгийн нийгмийн хэд хэдэн асуудлыг харгалзан хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот программыг хэрэгжүүлэх, БНМАУ-ын хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад онцгой анхаарах болно. ЗХУ-ын техникийн тусламжтайгаар байгуулагдсан хөдөө аж ахуйн объектуудын ажлын үр дүнг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

1986 оны 1 сарын 15-нд гарын үсэг зурсан 1986—1990 онд эдийн засаг, шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах тухай

ЗСБНХУ, БНМАУ-ын хоорондын хэлэлцээр нь Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны урт хугацааны программыг хэрэгжүүлэх явцад чухал үе шат болно.

Шинэ таван жилд зөвлөлт— Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа БНМАУ-ын эдийн засгийн тэргүүн ээлжит зорилт болох хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах, хүн амын хүнсний болон ард түмний хэрэгцээт барааны хангамжийг сайжруулах, түлш эрчим хүчний цогцолбор, олзворлох болон дахин боловсруулах үйлдвэрүүдийн хөгжилтийг түргэтгэх, барилгын үйлдвэрлэл болон орон нутгийн экспортын хүчин чадлыг аль болохоор нэмэгдүүлэх асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Үүнтэй холбогдон Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны объектын тоо, арга хэмжээ шинэ таван жилд 1981-1985 оныхтой харьцуулахад 1,5 дахин өснө.

Эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны хэлбэрийг цаашид боловсронгуй болгож, түүний үр дүнг дээшлүүлэхэд зохих анхаарал тавина. ЗХУ-ын техникийн тусламжтайгаар Монголын байгууллагуудын хүчээр баригдаж буй объектуудын тоо өсөхийн зэрэгцээ зөвлөлтийн барилгын байгууллагуудад ажиллах монголчуудын тоо нэмэгдэж, зөвлөлт, Монголын байгууллагуудын хамтын хүчээр баригдах объектууд өргөжих болно.

Зөвлөлтийн зохих байгууллагуудын тусламжтайгаар БНМАУ-ын шинжлэх ухаан техникийн дэвшлийн 15—20 жилийн цогцолбор программыг ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын шинжлэх ухаан-техникийн дэвшлийн 2000 он хүртэлх цогцолбор программтай нягт уялдуулан боловсруулна.

Социалист Монголын хөгжил, нүүр царайг тодорхойлж байгаа бүх амжилт, техникийн сүүлийн үеийн ололт амжилтанд түшиглэсэн үндэсний олон салбарт аж үйлдвэр, үйлдвэрийн бүхэл бүтэн төвүүд, механикжуулсан социалист хөдөө аж ахуй, бүх нийтийн бүрэн дунд боловсролыг хэрэгжүүлэх нөхцөлүүд бүрдэж буй ардын боловсролын систем, дэлхийн социалист урлагийн санд өөрийн хувь нэмрээ оруулж байгаа үндэсний, соёл урлагийн ололт амжилт, орчин үеийн шинжлэх ухааны бүх салбарын хөгжил олон улсын хамтарсан шинжилгээнүүд, түүний дотор «Интеркосмос» программыг хэрэгжүүлэхэд оролцож, БНМАУ-ын иргэн сансарт ниссэн зэрэг энэ бүхэн нь зөвлөлт— Монголын найрамдлын бодит үр дүн билээ. Зөвхөн сүүлийн 25 жилд ЗХУ-ын тусламжтайгаар Монголд 150 аж үйлдвэрийн газрыг оролцуулан 600 гаруй улс ардын аж ахуйн объект баригджээ. Түлш эрчим хүч, уул уурхай, хөнгөн, хүнсний, төмөрлөг боловсруулах болон барилгын үйлдвэр, тээвэр холбоо зэрэг аж үйлдвэрийн бусад салбарууд байгуулагдан хөгжлөө. Хөдөө аж ахуйн материал техникийн бааз үлэмж бэхжив.

БНМАУ-д социалист бүтээн байгуулалтын зорилтууд гүнзгийрэх тусам зөвлөлт-Монголын найрамдлын ач холбогдол улам нэмэгдэж, түүний цар хэмжээ өсч, агуулга нь баяжиж, хоёр орны хамтын ажиллагааны хэлбэр боловсронгуй болж, нийгмийн амьдралын бүх салбар дахь түүний бүтээлч роль нэмэгдэж байна.

ЗСБНХУ, БНМАУ-ын найрамдал, хамтын ажиллагааны орчин үеийн шат нь нийгэм-улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн болон соёлын амьдралын бүх шинэ шинэ талыг хамарсан нийгмийн хөгжлийн бүх салбаруудад аль болохоор ойртон нягтрах явцын гүнзгийрлээр тодорхойлогдож байна. Энэ хамтын ажиллагааны шинэ өндөр төвшин, үр дүнтэй хэлбэрүүд нь улс ардын аж ахуйн томоохон асуудлыг шийдвэрлэхэд нэгдсэн чармайлт гаргах, үйлдвэрлэлийн хоршолт дагналтыг

гүнзгийрүүлж, хамтран төлөвлөх практикийг баяжуулах, туршлагаа өргөнөөр солилцох, аж ахуйн хамтарсан нэгдлүүдийг байгуулах зэрэгт тусгалаа олж байна. Төвийн эрчим хүчний системийг ЗХУ-ын эрчим хүчний системтэй холбосон явдал нь БНМАУ-ын улс ардын аж ахуйн эрчим хүч ашиглах баазыг бэхжүүлэх чухал том алхам боллоо.

Үйлдвэрлэлийн хамтарсан нэгдэл, газрууд нь улс хоорондын үйлдвэрлэлийн хэрэгслийн хамтын өмч, ах дүү орнуудын хөдөлмөрчдийн хамтарсан чармайлт дээр үндэслэж, социалист орнуудын хамтын ажиллагааны ирээдүй бүхий шинэ төлвийг нэвтрүүлэхэд үлгэрлэж байна. Ах дүү ард түмний хамтын хөдөлмөр нь манай ард түмнүүдийн харилцан туслалцах, ойртон нягтрахын сургууль, интернационалч найрамдал, ах дүүгийн барилдааны жинхэнэ батжилтын сургууль интернационалч хамт олон бүрэлдэн тогтохын идэвхитэй хүчин зүйл болж байгаад хамтарсан үйлдвэрүүдийн онцгой үнэ цэнэ оршино.

Монголын хөдөлмөрчид социалист бүтээн байгуулалтын зорилтыг шийдвэрлэх үйл хэрэгтээ Зөвлөлтийн ард түмний туршлагыг улам өргөн хэмжээгээр идэвхитэй судалж, хэрэглэж байна. Тухайлбал, Ленинградын хамтлагуудын нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, Львовын бүтээгдэхүүний чанарын удирдлагын цогцолбор систем, ургац хураалтыг иж бүрэн зохион байгуулах Ставрополийн хязгаарын туршлага зэрэг болно. Одоо БНМАУ-д 200 орчим үйлдвэр, аж ахуйн газрууд, үйлчилгээний байгууллагууд Львовын системээр ажиллаж байна. Бүх сангийн аж ахуйн 70 %-д, газар тариалан эрхэлдэг хөдөө аж ахуйн олон нэгдэлд Ипатовын районы туршлагыг нэвтрүүлж байна. Зөвлөлтийн нэрт барилгачин Н. А. Злобины жишээгээр БНМАУ-ын барилгын хорооны системийн бригадуудын бараг тал хувь нь аж ахуйн тооцоонд шилжив. Тэд барилга—монтажийн бүх ажлын 56 %-ийг гүйцэтгэж байна.

Манай хоёр орны хамтын ажиллагааны алхам бүр нь яруу алдарт уламжлалаа арвижуулан баяжуулахад тодорхой хувь нэмэр оруулж, түүнийг цаашид гүнзгийрүүлэх шинэ бололцоог бий болгож байна.

Өнгөрсөн оны 8-р сард Москвад болсон ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев МАХН-ын Төв Хороо ны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх нарын нөхөрсөг уулзалт хоёр талын харилцааны болон олон улсын байдлын бүх асуудлаар ах дүү хоёр нам, хоёр орны байр суурь бүрэн нэгдмэл байгааг дахин яруу тодоор илтгэн харуулж, манай улсуудын хоорондох уламжлалт бүх талын хамтын ажиллагааны хөгжилд шинэ үе шат, ирээдүйн өргөн төлөв нээсэн юм.

Энэ уулзалтын үеэр гарын үсэг зурсан ЗСБНХУ, БНМАУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааг 2000 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны програмийг хэрэгжүүлэх явдал тус орны эдийн засаг, шинжлэх ухаан техникийн потенциалыг шинээр нэмэгдүүлэн БНМАУ-д социализмын материал — техникийн бааз байгуулж дуусгах зорилтыг амжилттай шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх болно.

Ах дүү социалист бүх орнууд нийтлэг зорилтдоо дөхөх явцад бие биедээ харилцан туслалцах үндсэн дээр хүчин чармайлтаа уялдуулан нэгтгэж л байж орон тус бүр дотоод бололцоогоо нэлээд бүрэн дүүрэн,

үр дүнтэй ашиглаж чадах тухай марксизм-ленинизмын үндсийг тавигчдын үзэл санааг ЗСБНХУ, БНМАУ-ын хамтын ажиллагааны өнөөгийн практик баталж байна.

Ах дүү орнуудын нэгдэл нягтрал, бүх талын хамтын ажиллагаанд тэдний хүч чадлын цаглашгүй эх булаг, ялагдашгүй баталгаа, цаашдын бүх талын дэвшлийн чухал шижим оршино.

«Проблемы Дальнего Востока» сэтгүүлийн  
1986 оны № 2-оос **Ч. Батцэцэг** товчлон  
орчуулав.